



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 09 сарын 28 өдөр

Дугаар

A/199

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн 2015 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шүүхийн шийдвэр биелүүлүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, тоо бүртгэл хөтлөх журмыг нэгдүгээр хавсралтаар, төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрх түдгэлзүүлэх тухай мэдэгдэх хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд мөрдөн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шийдвэр гүйцэтгэх газар /хурандаа Ж.Наранбаатар/-т даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2012 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн A/62 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Б.БИЛЭГТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий
газрын даргын 2015 оны 09 дүгээр сарын
28-ний өдрийн 4 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР БИЕЛҮҮЛЭЭГҮЙ
ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙН ГАДААДАД ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ
ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ТОО БҮРТГЭЛ
ХӨТЛӨХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, хүлээн авахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Төлбөр төлөгч гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-д заасныг ойлгоно.

Хоёр.Гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх

2.1.Шийдвэр гүйцэтгэгч нь гадаадад зорчих, цагаачлах эрх түдгэлзүүлэх ажиллагааг гүйцэтгэхийн өмнө төлбөр төлөгчид урьдчилан мэдэгдэх хуудсаар мэдэгдэнэ

2.2 Мэдэгдэх хуудсыг төлбөр төлөгчид хүргүүлэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 20 дугаар зүйлийг баримтална. Мэдэгдэх хуудсыг төлбөр төлөгчид гардуулах боломжгүй тохиолдолд баталгаат шуудангаар хүргүүлж нотлох баримтыг хавсаргана.

2.3.Энэ зүйлийн 2.1-д заасан ажиллагааг гүйцэтгэснээс хойш ажлын 5 хоногийн дотор шийдвэр гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх алба, хэсэг нь төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх саналыг, мэдэгдэх хуудсын хамт албан бичгээр Шийдвэр гүйцэтгэх газарт ирүүлнэ.

2.4.Төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх тухай албан бичигт шүүхийн шийдвэрийн огноо, дугаар, төлбөр төлөгч, төлбөр авагчийн овог нэр, регистрын дугаар, төлбөрийн хэмжээ, гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэл тодорхой тусгагдсан байна. Гадаадын харьяат төлбөр төлөгчийн овог, нэрийг паспорт дээр бичигдсэн англи галигаар бичнэ.

2.5.Төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг дараахь үндэслэлээр түдгэлзүүлнэ.

2.5.1.эд хөрөнгө, орлогоо нуун дарагдуулсан, төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн;

2.5.2.эд хөрөнгийн мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, худал мэдүүлэг өгсөн;

2.5.3.гадаад улсад гарсан нь нотлох баримтаар тогтоогдсон;

2.5.4.гадаад улс руу оргон зайлж болзошгүй талаар мэдээлэл ирсэн;

2.5.5.эрэн сурвалжлах ажиллагаа явагдаж байгаа.

2.6.Шүүхийн шийдвэрт заагдсан мөнгөн төлбөрийн үүрэг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төлбөр, 6 сараас дээш

хугацаагаар төлөгдөөгүй хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлнэ.

2.7. Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба, хэсгээс ирүүлсэн саналыг Улсын ерөнхий гүйцэтгэгч хянаж, гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

2.8. Энэ зүйлийн 2.7-д заасны дагуу төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэлтэй гэж үзвэл энэ тухай Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх газарт албан бичгээр болон цахимаар ажлын 5 хоногийн дотор мэдээлэл хүргүүлнэ.

2.9. Аймаг, нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх алба, хэсгээс ирүүлсэн санал энэ журамд заасан шаардлага хангаагүй, төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэл тогтоогдоогүй бол ажлын 5 хоногт багтаан саналыг албан бичгээр болон цахим хаягаар ирүүлсэн газарт нь буцаана.

Гурав. Гадаадад зорчих, цагаачлах эрхийг сэргээх

3.1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тогтоол үйлдсэн тухайн өдөр аймаг, нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх алба, хэсэг нь төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг сэргээх санал болон тогтоолын хуулбарыг албан бичгээр болон цахим хаягаар Шийдвэр гүйцэтгэх газарт ирүүлнэ.

3.2. Төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг сэргээх тухай албан бичгийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан Иргэний, харьяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх газарт мэдээлэл хүргүүлж, хариуг албан бичгээр болон цахим хаягаар хүлээн авна.

3.3. Төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг дараахь үндэслэлээр сэргээнэ.

3.3.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаасан;

3.3.2. гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн ажиллагааг шүүхийн шийдвэрээр хүчингүйд тооцсон;

3.4. Төлбөр төлөгч хувийн болон албан ажлаар гадаад улсад зорчих, эмчилгээ хийлгэх зайлшгүй шаардлагаар явах тохиолдолд зорчих эрхийг түдгэлзүүлсэн шийдвэрийг цуцлуулах хүсэлтийг гаргаж болно. Хүсэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх алба, хэсэг энэ зүйлийн 3.1-д заасны дагуу санал ирүүлнэ.

3.5. Энэ зүйлийн 3.4-д заасан саналд төлбөр төлөгчийн гадаад улс явах болсон үндэслэлийг нотолсон хурал, зөвөлгөөний хөтөлбөр, урилга, виз, өөрөө эмчилгээ хийлгэх болсон эсхүл гэр бүлийн гишүүн гадаад улсад нас барсан, эмчилгээ хийлгэх шаардлагатай гэр бүлийн гишүүнийг асрах шаардлагатай болсныг нотолсон эмнэлгийн байгууллагын дүгнэлт, оршин суугаа сум, хорооны Засаг даргын тодорхойлолтыг хавсаргасан байна.

Дөрөв. Эрх шилжүүлэх

4.1. Төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх асуудлыг Улсын ерөнхий гүйцэтгэгчийн эзгүйд түүний тушаалаар эрх олгогдсон албан тушаалтан хянан шийдвэрлэнэ.

Тав. Түр саатуулагдсан төлбөр төлөгчийг хүлээн авах

5.1. Гадаадад зорчих, цагаачлах эрхийг нь түдгэлзүүлсэн төлбөр төлөгч улсын хилээр саатуулагдсан тохиолдолд түүнийг дараахь алба, хэсэг хүлээн авна.

5.1.1. Буянт-Ухаа дахь хилийн боомт-Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба, Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын алба;

5.1.2. Арц суурийн боомт-Завхан аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба;

5.1.3. Тэшигийн боомт-Орхон аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба;

5.1.4. Улаанбайшинт, Цагааннуур, Даянгийн боомт-Баян-Өлгий аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба;

5.1.5. Боршоо, Тэсийн боомт-Увс аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба;

5.1.6. Ханхын боомт-Хөвсгөл аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба;

5.1.7. Байтаг, Булганы боомт-Ховд аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба;

5.1.8. Хавирга, Баянхошуу, Сүмбэрийн боомт-Дорнод аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба;

5.1.9. Хангийн боомт-Дорноговь аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба;

5.1.10. Бичигтийн боомт-Сүхбаатар аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба;

5.1.11. Замын-Үүдийн боомт-Дорноговь аймгийн Замын үүд дэх Шийдвэр гүйцэтгэх хэсэг;

5.1.12. Гашуун сухайт, Шивээ хүрэнгийн боомт-Өмнөговь аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба;

5.1.13. Сүхбаатар, Алтанбулагийн боомт-Сэлэнгэ аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба.

5.2. Саатуулагдсан төлбөр төлөгчийг гадаад паспорт, нотломжийн хамт хүлээн авч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу үзлэг нэгжлэг хийж, тэмдэглэл хөтөлнө.

5.3. Төлбөр төлөгчийн биед болон эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх үед бэлэн мөнгө, валют, үнэт эдлэл илэрсэн тохиолдолд төлбөрийн хэмжээнээс илүүгүй хэмжээгээр хураан авна.

5.4.Төлбөр төлөгчөөс хураагдсан бэлэн мөнгө, гадаад валют, үнэт эдлэлийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тэмдэглэлийн хамт харьяалах Шийдвэр гүйцэтгэх алба, хэсэгт нэн даруй хүлээлгэн өгнө.

5.5.Саатуулагдсан төлбөр төлөгчийг хүлээн авахтай холбоотой гарсан зардлыг тухайн этгээдээс гаргуулна.

5.6.Хилийн боомтыг харьяалах Шийдвэр гүйцэтгэх алба, хэсэг нь саатуулагдсан төлбөр төлөгчийн мэдээлэл, танилцуулгыг түүний гадаад паспортын хамт Шийдвэр гүйцэтгэх газар ирүүлнэ.

Зургаа.Тоо бүртгэл хөтлөх, хяналт тавих

6.1.Шийдвэр гүйцэтгэх газар нь төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн болон сэргээсэн ажиллагааны талаар нэгдсэн тоо бүртгэл, хөтөлж хяналт тавина.

6.2.Нэгдсэн тоо бүртгэлийг Шийдвэр гүйцэтгэх газрын Мэдээлэл, лавлагаа дүн шинжилгээ хариуцсан нэгж нь Иргэний, харьяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх газартай улирал тутам тулгалт хийж, мэдээллийг Хууль зүйн яаманд хүргүүлнэ.

6.3.Аймаг, нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх алба, хэсэг гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн төлбөр төлөгчдийн судалгааг сар бүрийн 25-ны дотор Шийдвэр гүйцэтгэх газарт ирүүлнэ.

Долоо.Хүлээлгэх хариуцлага

7.1.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий
газрын даргын 2015 оны 09 дүгээр сарын
28-ний өдрийн 1/199 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

**ГАДААДАД ЗОРЧИХ ЭРХ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ
ТУХАЙ МЭДЭГДЭХ ХУУДАС**

.....оны.....сарын.....-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

.....аймаг /нийслэл/-ийнр хороо /баг/-ны
.....гудамж.....р байрны.....тоот /хашаа, байшин/-д оршин
суух.....овогт.....-нытаныг
.....шүүхийнонысарын.....-ны өдрийн
.....тоот шийдвэр /тогтоол, захирамж/-ээр
.....ны.....нд
төлөх.....төгрөг /валют/-ийн төлбөрийг төлөөгүй, шүүхийн
шийдвэрийг биелүүлээгүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулж байх тул
таныг улсын хилээр үл нэвтрүүлэх иргэдийн нэрсийн жагсаалтад оруулах болсныг
урьдчилан мэдэгдэж байна.

Мэдэгдэл хүргүүлсэн:

.....тойргийн шийдвэр гүйцэтгэгч...../...../

Мэдэгдэл хүлээн авсан:

Төлбөр төлөгч...../...../

.....оны.....сарын.....-ны өдөр

.....цаг.....минут